



ХИЧЭЭЛ 11

УНШИХ ЗҮЙЛ: МАТАЙ 1:18-25; ЛУК 1:26-38; 2:8-14; ДАГАЛДАГЧДЫН ҮЙЛС, Х. 43-48.

Бурханы Элч Нар

Та нар сайхан мэдээ сонсмоор байна уу?
Олон жилийн өмнө тэнгэр элч нар зарим
хүмүүст сайхан мэдээ хүргэсэн юм.

Г

абриел нэртэй тэнгэр
элч дэлхий руу яаран
бууж ирэв. Тэр яг
хаана очихоо сайн
мэдэж байсан юм.

Тэрээр Назар гэдэг
жижиг хотыг чиглэн явна. Марь гэдэг
онцгой бүсгүйтэй уулзах ёстой гэдгээ ч
тэр сайн мэдэж байсан юм. Тэрээр
Бурханы үгийг дамжуулах ёстойгоо сайн
мэднэ.

"Марь" гэж Габриел
түүнийг зөөлөн дуудав.
"Бүү ай. Бурхан чамайг
онцгойлон сонгожээ.
Үргэлж чамтай хамт байх
болно."

Марь маш их гайхаж байсан юм. Тэрээр бас яах учраа
мэдэхгүй байлаа.

Үзэсгэлэнт тэнгэр элч Габриелын хэлэх үг бүрийг Марь
анхааралтай чагнаж байлаа.

"Та хүүтэй болно. Хүүгээ Есүс гэж нэрлээрэй. Тэр бол



Цээжлэх Ишлэл:

"Бурхан элч нараа
туслуулахаар
илгээдэг"
ЕВРЕЙ 1:14.

Тол Санаа:

Бурхан бидэнд
туслуулахаар тэнгэр
элчээ илгээдэг.

Бурханы хүү юм" гэж Габриел цааш нь үргэжлүүллээ.

Түүнийг бүх зүйлийг хэлж дуусахад Марь "Бүх зүйл хэлснээр чинь болох болтугай" гэж хариулав.

Бараг тэр үед Бурхан Иосеф рүү элчээ илгээсэн байна. Их Эзэний үзэсгэлэнт элч түүний зүүдэнд үзэгдэв.

"Марийг эхнэрээ болгон авагтун. Тэрээр хүү төрүүлнэ. Хүүг Есүс гэж нэрлээрэй. Тэр өөрийнхөө хүмүүсийг гэмээс аврах болно."

Иосеф сэрлээ. Тэрээр орон дээрээ босоод суув. *Тэнгэр элч!* гэж Иосеф боджээ. *Бурхан над руу тэнгэр элчээ илгээжээ.*

Бяцхан Есүсийг мэндэлсний дараа өөр нэгэн элч хоньчид дээр хүрч ирэв. Тэд хонио хэвтүүлээд унтаж байсан.

Гэнэт тэдний дээр тэнгэр элчийн гэрэл бий боллоо. Тэд айж байсан юм. "Бүү айцгаа" гэж тэнгэр элч хэлсэн байна. "Би та нарт сайн мэдээ авчирлаа. Та нарын Аврагч Эзэн өнөөдөр Бетлехем хотод мэндэллээ."

Дараа нь олон тэнгэр элч нар гарч ирж дуу дуулсан юм. "Мөнхийн улсдаа залрах Бурханыг магтагтун" хэмээн гайхамшигтайгаар сайхан дуулжээ.

"Хорвоо дэлхий амгалан байг."


Тэнгэрт аялгуу сайхан хөгжим дүүрэн цуурайлтлаа.

Дараа нь тэр олон тэнгэр элч нар мөнхийн оршихуй руу буцжээ. Бурханы тэдэнд даалгах дараагийн чухал ажил юу бол?

Тэнгэр элч нар үргэлж Бурханы ажлыг хийхэд бэлэн байдаг. Тэд мэдээ хүргэдэг бас биднийг харж ханддаг.

Бурхан та нарыг хамгаалах, үргэлж хамт байх онцгой хамгаалагч элч нарыг та нарт өгсөн. Та нарыг хаашаа ч явсан, юу ч хийсэн тэнгэр элч чинь хамтдаа байх болно.

Бурхан үнэхээр сайн Эзэн байна шүү дээ.



Дасгал Ажил

ШАББАТ

Энэ долоо хоногийн турш өдөр бүр Библийн түүхээ уншиж, цээжилсэн ишлэлээ хамтдаа давтаарай.

- Бурхан**Дээшээ заах.
- элч нараа**Гараа далавч мэт зөөлөн дэвэх.
- туслуулахаар**Зүүн нударгаа баруун алганыхаа дор барьж байгаад дээш нь эргүүлж цээж рүүгээ болгох.
- илгээдэг.**Баруун гараа саравчлан дээш доош харах.
- Еврей 1:14**.....Алгаа нийлүүлээд дэлгэнэ.

НЯМ

Шаббат хичээл дээр хийсэн тэнгэр элчээ хэн нэгэнтэй хуваалцаж түүнд мөн Есүсийн тухай мэдээ дамжуулсан тэнгэр элчийн тухай ярихад нь хүүхдээ урамшуулаарай. (Эсвэл тэнгэр элч зураад, хүүхдээрээ будуулаарай. Дараа нь түүнийгээ хайчлаад ард нь модон бариул наагаарай.)



ДАВАА

Матай 1:18-25; Лук 1:26-38; 2:8-14-г хамтдаа уншина уу. Асуух: Тэнгэр элч нар хэн дээр очсон бэ? Тэд ямар мэдээ хүргэсэн бэ? Түүхэн дээр гарч байгаа хүмүүс ямар сэтгэгдэлтэй байсан бэ? (айсан балмагдсан) Та нарыг хамгаалдаг тэнгэр элч нарын хамгийн гол үүрэг юу вэ?

МЯТМАР

Хүүхдээрээ Библид гардаг тэнгэр элчтэй түүхүүдийг нэрлүүлж тэр болгонд нь үсэргээрэй. Жагсаалт гаргаж тэдгээрийг бичихэд нь хүүхдэдээ туслаарай.

ЛХАГВА

Захидлын хэмжээтэй цаасыг конус хэлбэртэй болгож хуйлаад чанга яригч хийгээрэй. Асуух: Чи сайхан мэдээ сонсохоороо шивнэж хэлэхийг хүсдэг үү эсвэл чанга хашгирч хэлэхийг хүсдэг үү? Хүүхдэдээ чанга яригчаа бариулаад гэр дотуураа "Есүс надад хайртай" гэж хашгируулан алхуулаарай.



ЛҮРЭВ

Хүүхдээсээ асуух: Тэнгэр элч нар Иосеф Марь хоёрт хүүгээ хэн гэж нэрлээрэй гэж хэлсэн бэ? (Есүс) Энэ нэр нь хүмүүсийг гэмээс аврагч хүн гэсэн утгатай. Хүүхдэдээ яагаад нэрийг нь өгсөн бэ гэдгээ тайлбарлаж хэлж өгөөрэй. (хэрвээ та мэддэг бол)

БААСАН

Марь, Иосеф болон хоньчдод дээр тэнгэр элч ирж байгаа хэсгийг гэртээ жүжиглээрэй. Хүүхдээрээ тэнгэр элчид тоглож байгаа хүн рүү гар чийдэн тусгуул. (хүүхэд тань ч тэнгэр элч болж болно.) Тэнгэр элч нар хоньчид дээр ирсний дараа зул сарын дуу дуулах эсвэл сонсоорой.

Тэнгэр элч гэр бүлийг тань хамгаалсан гэж бодсон үйл явдлын талаар хүүхдэдээ ярьж өгөөрэй.